

ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

НЭГ. ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

УБЕГазар болон Иргэний улсын бүртгэлийн газраас албан бичгээр ирүүлсэн **13** удаагийн үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа.

- ❖ 2022 оны 01 сарын 06-ний өдрийн 4/134 тоотоор иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг цахимжуулах тухай албан бичгийг хүлээн авч сумдын улсын бүртгэгчдэд зоом-ээр заавар, мэдээлэл өгч хэрхэн яаж цахимжуулах талаар УБЕГазраас ирсэн чиглэлийн дагуу зөвлөмж өглөө. Өнгөрсөн оны 9 сараас иргэний улсын бүртгэлийн онлайн системийг хэрэглээнд нэвтрүүлж, КОЙКА-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн төслийн хүрээнд улсын бүртгэгчдийн тоног төхөөрөмж бүрэн шинэчлэгдэж иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах бүрэн боломж бүрдсэн. Энэ ажлын хүрээнд мэдээлэл технологийн ажилтан улсын бүртгэгчдийн компьютер тоног төхөөрөмжид программын тохиргоог хийж бэлэн байдлыг ханган ажиллалаа. Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах ажлын хүрээнд иргэний гэр бүлийн 1212 бүртгэлийн 3771 хуудас, иргэний үнэмлэхийн 1766 бүртгэлийн 3000 хуудас, шилжилт хөдөлгөөний 1671 бүртгэлийн 3346 хуудас, гадаад паспортын 100 бүртгэлийн 100 хуудас нийт **4749** бүртгэлийн **10217** хуудас баримтыг цахимжуулсан байна. Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулснаар цахимжуулсан баримтыг ашиглах, засварлах программын хэрэглээ сайжирч цаг хугацааг хэмнэж мэдээллийг түргэн шуурхай солилцох, дамжуулах нөхцөл боломж бүрдсэн.
- ❖ Иргэний Улсын бүртгэлийн газар, Улсын бүртгэлийн нэгдсэн архиваас 2022 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн “Баримт цахимжуулах тухай” 10/ 796 дугаар чиглэлийн дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд 86 иргэний жагсаалт ирсэн. Тус ажлын хүрээнд 68 иргэний мэдээллийг шалгахад эцгийн мэдээлэл ороогүй 9, эхийн мэдээлэл ороогүй 52 бүртгэлийг оруулсан бөгөөд нийт 68 иргэний 80 ширхэг цаасан баримтыг архивын санд бүрэн цахимжуулсан. Мөн Улсын бүртгэлийн нэгдсэн архивын 2022 оны 02 сарын 23-ны өдрийн 10/1536 дугаартай албан бичгийг хүлээн авч улсын бүртгэгчдэд танилцуулан мөрдөж ажиллахыг үүрэг болголоо.
- ❖ 2022 оны 01 сарын 11 өдрийн дотоод мэйлээр ирсэн 100 гаас дээш настай иргэдийн судалгааг ирүүлнэ үү гэсний дагуу тус аймгийн харъяат 100 настай 2 иргэний судалгааг гаргаж хүргүүллээ.
- ❖ ИУБГазрын 2022 оны 01 сарын 18-ны өдрийн 4/522 албан бичгийг хүлээн авч улсын бүртгэгчдэд танилцуулан иргэний улсын бүртгэлийг алдаагүй үнэн зөв хөтлөхөд хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, бүртгэлийн зөрүүг

арилгах иргэнд хүндрэл бэрхшээл учруулахгүй байхыг анхааруулч чиглэлийг мөрдөж ажиллахыг үүрэг болголоо. Мөн иргэний улсын бүртгэлийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах асуудалтай холбогдуулан ХШГазраас ирүүлсэн чиглэлийг улсын бүртгэгчдэд танилцууллаа.

- ❖ Улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 03 сарын 24-ний өдрийн 4/2584 тоот албан бичгийн дагуу иргэний үнэмлэхийн бүртгэлийг шалгах ажлыг зохион байгууллаа. Тус албан бичгийн хүрээнд сумдын улсын бүртгэгчдэд цахим сургалтын үеэр мэдээллийг өгч хэрхэн яаж шалгах талаар заавар зөвлөмж өгсөн. Тус аймгийн хэмжээнд 2020-2022 оны хооронд нийт 4689 иргэний үнэмлэх хэвлэгдэж иргэдэд олгосон байна. Үүнээс шинээр 16 нас хүрч биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдсан 1367 иргэн, 25 насны сунгалтаар 1174 ,45 насны сунгалтаар 1176 иргэн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдсан байна. Иргэний үнэмлэхийн зураг засах явцад гарч байгаа алдаа зөрчил, шаардлага хангахгүй зураг авсан тохиолдол тухай бүр хэлтсийн дотоод фэйж хуудас болон бүртгэгчдийн групп анхааруулга бичиж анхааруулж ажилладаг тул шаардлага хангахгүй зураг авах тохиолдол гарч байгаагүй.
- ❖ Иргэний улсын бүртгэлийн лавлагаа олгох тухай Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022 оны 04 сарын 07 ны өдрийн 4/3001 тоот чиглэлийг улсын бүртгэгчдэд танилцуулан лавлагаа олгох үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, холбогдох эх нотлох баримтын дагуу лавлагааг үнэн зөв олгоход анхаарч ажиллахыг зөвлөлөө. Мөн шинээр томилогдсон улсын бүртгэгчдэд лавлагааг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хэрхэн олгох, архивын цахимжуулсан программаас лавлагааг хэрхэн хайж лавлагааг иргэдэд олгох талаар программ дээр заавар өгч ажилласан.
- ❖ ИУБГазраас 2022 оны 05 сарын 24 ны 4/4585 тоот чиглэлээр Иргэний үнэмлэхийн бүртгэл хөтлөх тухай албан бичгийг хүлээн авч улсын бүртгэгчдэд танилцуулан иргэний үнэмлэхийн бүртгэлийг хөтлөхдөө цээж зургийг холбогдох шаардлага стандартын дагуу авах, мэдээллийн санд иргэний бүртгэлийг заавал шалгаж байхыг мөн иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн иргэдийг e.mongolia системээр иргэний үнэмлэхийн захиалгыг авч сурталчилж ажиллахыг зөвлөлөө.
- ❖ Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг 2022 оны 05 сарын 1-ний өдрөөс эхлэн олгож эхэлсэн. Тус аймаг 16 аас дээш насны 32044 иргэнд тоон гарын үсэг олгоно.Тоон гарын үсгийг бүртгэлийн 16 нэгжээр дамжуулан тоон гарын үсгийг олгож байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 10882 иргэн буюу 33,9 хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 9753 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 1129 иргэнд гар утасны gsign app- аар дамжуулан олголоо. Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх тухай УБЕГазрын даргын 2022 оны 09 сарын 14-ний өдрийн 1/7706 тоот чиглэлийн дагуу сар бүр хуваарь гарган ажиллаж сумдын бүртгэгчдэд өдөрт 5 иргэнд тоон гарын үсэг олгож ажиллах чиглэлийг хүргүүлж ажилласан. Мөн Луус сумын зөөврийн тоног төхөөрөмжийг 4 удаа аймгийн төвд ерөнхий боловсролын 5 сургууль, 6 аж

ахуй нэгж, төрийн байгууллага, үйлчилгээний төвд тоон гарын үсэг иргэдэд олгох ажлыг зохион байгуулсан.

- ❖ 2022 оны 5 сарын 18-ны өдрийн 4/4386 тоот чиглэлээр гадаад паспортын нотлох баримтыг 5 сарын 26 ны өдрөөс цахимжуулах тухай улсын бүртгэгчид танилцуулан хэлтсийн 2 улсын бүртгэгчид цахимжуулалтын эрх нээлгэн 6 сарын 1-ний өдрөөс хойш захиалсан 131 гадаад паспортын материалыг бүрэн цахимжууллаа.
- ❖ ИУБГазрын 2022 оны 08 сарын 08-ны өдрийн 4/6527 тоот чиглэлээр иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг цахимаар бүртгэх үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-mongoliaд нэвтрүүлсэнтэй холбоотой иргэдийн хүсэлтийг байнга шалган тухай бүр шийдвэрлэж ажиллахыг бүртгэгчдэд үүрэг болголоо.
- ❖ УБЕГазрын даргын 2022 оны 09 сарын 29-ны өдрийн 01/8275 тоот чиглэлээр үндэсний энгийн гадаад паспортад бичилт хийх үйлдвэрийг ашиглалтад оруулж байгаатай холбоотой гадаад паспортын бүртгэл хийхэд иргэнээс цээж зураг шаардахгүй улсын бүртгэгч өөрөө зургаа авч программд оруулж авдаг болсон асуудлын талаарх чиглэлийг улсын бүртгэгчдэд хүргэн иргэний улсын бүртгэлийн газраас гадаад паспортын программын талаар зохион байгуулсан сургалтад холбогдох улсын бүртгэгчдийг хамрууллаа. Мөн Иргэний бүртгэлийн газраас гадаад паспортын дугаар ороогүй 86 иргэний бүртгэлийн жагсаалт ирснийг шалгаж гадаад паспортын дугаарыг мэдээллийн санд шивж оруулсан. Гадаад паспортыг иргэдэд олгохдоо бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зуруулж олгодог байсан бол гадаад паспортын олголтын программыг ашиглалтад оруулсан зэрэг бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан үйлчилгээ болж чадлаа.
- ❖ Иргэний улсын бүртгэлийн газрын 2022 оны 11 сарын 02-ний өдрийн 4/9443 тоот чиглэлээр иргэний улсын бүртгэлийг баталгаажуулах тухай чиглэлийг бүртгэгчдэд хүргэлээ. 2022 оны 11 сарын 7-ны өдрөөс эхлэн сумдын улсын бүртгэгчид гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, иргэний үнэмлэхийн, биеийн давхцахгүй өгөгдлийн ,шилжилт хөдөлгөөний, нас барсны бүртгэлийг баталгаажуулж эхэлсэнтэй холбогдон бүртгэлийг алдаагүй үнэн зөв хөтлөх, бүртгэлийн эх нотлох баримтыг бүрэн гүйцэт бүрдүүлэн авч цахимжуулалт хийсний дараагаар баталгаажуулж байх тухай бүртгэгчдэд заавар өгч ажилласан.
- ❖ Иргэний улсын бүртгэлийн газраас ахлах бүртгэгчдэд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг шилжүүлсэнтэй холбогдон Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 03 сарын 03-ны өдрийн 1543, 2021/006839, 2022 оны 10 сарын 18-ны өдрийн 6256 тоот дүгнэлтийг үндэслэн нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг хийж байна. Иргэний улсын бүртгэлийн газраас гаргасан дээрх шийдвэрүүд нь цаг үеэ олсон иргэний бүртгэлийн шат дамжлагыг бууруулсан, цаг хугацааг хэмнэсэн бодит шийдвэрүүд болж чадлаа.

Аймаг, нийслэл сум дүүргийн ИТХурлын нөхөн сонгуулийн ажлын хүрээнд УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас дотоод албан бичгээр ирүүлсэн 7 удаагийн өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа.

- ❖ 2022.04.29-ний өдрийн А/284 тоот шилжилт хөдөлгөөн түр зогсоох тухай тушаалыг хүлээн авч улсын бүртгэгч нарт танилцуулан иргэдэд мэдээллийг хүргэж ажилласан.
- ❖ Election.gasr.mn программд нөхөн сонгууль явагдах Сайхановоо, Гурвансайхан, Дэлгэрцогт сумдын сонгуулийн хэсэг байгуулсан тухай ИТХурлын тогтоолыг шивж сумдад байнга оршин суугаа хаягийн бүртгэлтэй 1442 сонгогчид хэсэг оноолт хийгдсэн эсэхийг шалгасан.
- ❖ Иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн чиглэлийн дагуу Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн чиглэлийн дагуу төрийн 6 байгууллагын мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалтад тусгасантай холбоотой сонгогчдын нэрийн жагсаалтыг тулган нягтлалаа.
- ❖ УБГазраас өгсөн чиглэлийн дагуу Сонгогчдын нэрийн жагсаалтыг 2 хувь хэвлэн тамга тэмдгээр баталгаажуулан 6 сарын 25-ны өдөр Гурвансайхан, Сайхановоо, Дэлгэрцогт сумдын хэсгийн хороонд актаар хүлээлгэн өглөө.
- ❖ 2022 оны 6 сарын 19-ний өдрийн нөхөн сонгуульд нийт 1430 сонгогч санал өгөхөөс 702 сонгогч санал өгч 49.1 хувьтай явагдлаа. Сонгуулийн өдөр тоног төхөөрөмжид ямар нэг гэмтэл саад учраагүй хэвийн явагдсан.

2. Иргэний бүртгэлийн чиглэлээр:

2022 онд **10625** иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг хүргэж ажиллалаа. Тайлант хугацаанд ИГББүртгэлийн сар бүрийн тоон мэдээний нэгтгэлийг 11, иргэний үнэмлэх хүлээн авсан мэдээ 39 удаа, үнэт цаасны мэдээг 11 нэгтгэж нийт 61 удаа тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна. Тайлант хугацаанд 386 албан бичиг явуулж, 190 албан бичиг хүлээн авснаас 120 хариутай албан бичгийн хүрээнд 396 лавлагааг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

нийт **1766** иргэний үнэмлэх хэвлүүлж олгосноос шинээр **559**, хаяж үрэгдүүлэн дахин авсан **314**, хугацааны сунгалтаар **893** иргэнд иргэний үнэмлэх олгосон байна. Тайлант хугацаанд төрөлтийн бүртгэлд **701** хүүхэд, гэрлэлтийн бүртгэл **151**, үрчлэлт **12**, гэрлэлт цуцлалтын бүртгэл **34**, эцэг тогтоолтын бүртгэл **24**, ОНӨ бүртгэл **39**, нас барсны бүртгэлд **251** нийт **1212** бүртгэл, **1671** иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл, үндэсний энгийн гадаад паспорт **452** иргэн нийт **3335** бүртгэлийг мэдээллийн санд баталгаажуулсан байна.

Нийт **4589** лавлагаа хэвлэсэн бөгөөд хууль хяналтын байгууллагын хүсэлтээр **396** лавлагаа хэвлэж олгосноос цагдаагийн байгууллагын хүсэлтээр **231**, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн хүсэлтээр **152**, Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн хүсэлтээр **13**, лавлагааг тус тус олгосон. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлсэн **1452** иргэний зургийн засварыг хийж иргэний үнэмлэхийг хэвлүүллээ.

2022 онд 1671 иргэн шилжин ирсний бүртгэлд бүртгэгдсэнээс гадны аймаг хотоос 375 иргэн, 1296 иргэн аймаг дотор буюу сумаас суманд, багаас багт шилжин ирсэн бүртгэл хийлгэсэн байна. Гадны аймаг хотоос шилжин ирсэн бүртгэлээс Улаанбаатар хотоос 168 иргэн, Өмнөговь аймгаас 62, Дорноговь аймгаас 26 иргэн шилжин ирсэн нь нийт шилжин ирсэн хөдөлгөөний 68,6 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд 1324 иргэн өөр аймаг хотод шилжин явснаас 16- аас доош насны 393, 16-аас дээш насны 931 иргэн шилжилт хөдөлгөөний

бүртгэл хийлгэсэн байна. Улаанбаатар хотод 942 иргэн, Өмнөговь аймагт 146 иргэн, Говьсүмбэр аймагт 62 иргэн шилжсэн нь нийт шилжилт хөдөлгөөний 86.8 хувийг эзэлж байна. Шалтгаанаар нь авч үзвэл амьдралын нөхцөл сайжруулах гэсэн 397, бусад гэсэн шалтгаанаар 845 иргэн шилжсэн нь нийт шалтгааны 93,8 хувь байна.

Тус хэлтэс нь 2021 оны 10 дугаар сард “Гэрэгэ” киоск төлбөрийн машиныг үйлчилгээнд нэвтрүүлсэн бөгөөд төрийн болон төрийн бус 55 байгууллагын 600 гаруй төрлийн үйлчилгээний төлбөрийг төлөх боломж бүрдсэн. 2022 оны байдлаар 3860 иргэн гэрэгэ төлбөрийн системээр улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцоог хийсэн байна.

Эрүүл мэндийн яамны мэдээллийн сангаас 701 хүүхдэд регистрийн дугаарыг унагаж нийт төрөлтийн бүртгэлийг бүртгэсэн бөгөөд регистрийн дугаар зөрүүтэй олгогдсон 3 хүүхдийн бүртгэлийг УБЕГазрын Мэдээлэл технологийн газар болон ЭМДГазарт албан тоотыг хүргүүлэн регистрийн дугаарыг засварлуулан дахин олгож бүртгэлийг хөтөлсөн.

ГХБХБГазартай хамтран 2020,2021 оны Иргэдийн хурлын тогтоолоор баталсан аймгийн төвийн 5 баг болон 15 суманд шинэ суурьшлын бүс үүссэнтэй холбоотойгоор иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолын дагуу 66 гудамж, 5 байрны хаягийг УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газар болон Мэдээлэл технологийн газарт жагсаалтыг хүргүүлэн хаягийн санд тусгууллаа.

Иргэний бүртгэлийн тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нэг гол ажил бол мэдээллийн сангийн төрөлтийн бүртгэлд овог нэр, бүртгэлийн дугаар, төрсөн он сар дутуу алдаатай орсон, эцэг эхийн мэдээлэл дутуу тусгагдсан зэрэг зөрчилтэй 6100 иргэний зөрчлийг мэдээллийн санд зөрчилгүй болгох ажил байсан. Тус ажлын хүрээнд улсын бүртгэгчдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэг бүртгэгч 350 иргэний бүртгэлийн зөрчлийн архивын цахимжсан материалыг харах ашиглах программ хангамж, онлайн мэдээллийн системийг ашиглан зөрчлийг шалган эх нотлох баримтад үндэслэн мэдээллийн санд тусгуулах ажлыг зохион байгууллаа.

Үүнд: - бүртгэлийн дугаар ороогүй – 24

- эхийн мэдээлэл ороогүй- 1486

- эцгийн мэдээлэл ороогүй-1784

- ОНӨ- бүртгэлийн алдаатай -478

- эцэг тогтоолтын бүртгэл алдаатай -316

- үрчлэлтийн бүртгэл алдаатай -76

- бүртгэлийн он сар өдөр буруу орсон

- хяналтын байцаагчийн дүгнэлтээр -

- өөр аймаг хот руу шилжин

- 2 регистрийн дугаартай

- ургийн овог ороогүй-

- 330

430

явсан - 352

– 10


814 бүртгэлийн зөрчлийг арилгалаа.

E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системээр иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн **235** иргэнд иргэний үнэмлэх захиалан олгосон байна.

ИГББүртгэлийн маягт, анхан шатны нотлох баримтыг цахимжуулж

байгаатай холбогдон ИГББ маягт, шилжилт хөдөлгөөн, ИУБ-31 маягтуудыг мэдээллийн санд хэрхэн цахимжуулж байгааг цахим сантай тулган шалгасан. Цахимжуулалтыг 1 сарын 10-ны өдрөөс эхлэн хийсэн бөгөөд түүнээс өмнө бүртгэгдсэн цахимжуулалт хийгдээгүй ирүүлсэн ИГББүртгэлийн 26 маягт, шилжилт хөдөлгөөний 14 маягт, ИУБ-31 маягт 35 ш маягтыг сумдад буцаан хүргүүлж цахимжуулах ажилд хяналт тавин ажилласан.

Хяналтын улсын байцаагчаас 2022 оны 10 сарын 1-ний өдрөөс 2022 оны 11 сарын 1-ний өдөр хүртэлх 400 бүртгэлийн анхан шатны нотлох баримтын цахимжуулалтад



хяналт орж улсын бүртгэгчдэд цахимжуулалтын явцад шаардлага хангахгүй цахимжуулсан бүртгэлийг дахин цахимжуулах, эх нотлох баримтыг цахимжуулахад анхаарах асуудлаар заавар зөвлөмж өгч ажилласан.

4.Иргэний бүртгэлийн архивын үйл ажиллагаа:

2022 оны эхний хагас жилд бүртгэсэн төрөлтийн бүртгэл 701 хүүхэд, гэрлэлтийн бүртгэл 151, үрчлэлт 12, гэрлэлт цуцлалтын бүртгэл 34, эцэг тогтоолтын бүртгэл 24 , ОНӨ бүртгэл 39, нас барсны бүртгэлд 251 шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 1671 маягт, ИУБ-31 маягт 1452 ш нийт 4335 бүртгэлийн маягтыг архивт шилжүүллээ .

Өөр аймаг хотоос шилжин ирсэн 652 иргэний хувийн хэргийг хүлээн авч архивын санд байрлуулан, өөр аймаг хот руу шилжин явсан 358 ш хувийн хэргийг холбогдох аймгуудад хүргүүллээ. ИУБүртгэлийн ИУБ 11- 18 маягт 1250 ш, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдсан 1344 иргэний ИУБ-31 А маягт нийт 2594 маягтыг Иргэний баримтын архивт хүргүүллээ.

2022 онд хадгалах хугацаа дууссан үндэсний энгийн гадаад паспорт бүртгэлийн дэвтэр 3 ш, иргэний үнэмлэх дахин олголтын анкет, бүртгэлийн дэвтэр 4 ш, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр 24 ш, улсын бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа олгосон бүртгэлийн дэвтэр 17 ш нийт 45 бүртгэлийн дэвтрийн 4980 хуудас баримтыг устгах баримт бичгийн жагсаалтыг гарган хэлтсийн баримт бичиг нягтлан шалгах комиссоор оруулан шийдвэрийг УБЕГазрын баримтын архивт хүргүүлэн устгахад бэлэн болгосон.

5. Бүртгэлийн үйл ажиллагааны сургалт, сурталчилгаа:

Тайлант хугацаанд Говьугтаал, Луус, Цагаандэлгэр сумдын улсын бүртгэгчид шинээр томилогдсонтой холбогдон хэлтсийн даргын тушаалаар батлагдсан ажил хүлээлцэх ажлын хэсэг бүртгэгчдэд ажлыг хүлээлцэн улсын бүртгэгчдэд ажлын байрны дадлага, хууль эрх зүй, программ хангамжийн сургалтыг дараах сэдвийн хүрээнд Сайнцагаан сумын улсын бүртгэгчийн ажлын байран дээр хийлгэж ажилласан.

Үүнд: иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомж, мөрдөгдөж байгаа журам,иргэний бүртгэлийн систем дээр бүртгэлийг хэрхэн хөтлөн явуулах, анхан

шатны нотлох баримтын бүрдүүлбэр, журнал бүртгэл хөтлөлт, тайлангийн нэгдсэн программ, архивын цахимжуулсан программыг хэрхэн ашиглах, лавлагаа хэрхэн гаргах, төрийн албан хаагчийн ёс зүй, хүний нөөцийн сургалтын программыг тогтмол ашиглан бүртгэлийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааг сум орон нутагт сурталчлан ажиллах талаар заавар зөвлөмжийг холбогдох албан хаагчид өглөө. Бүртгэгчдийн программын эрхийг иргэний улсын бүртгэлийн газарт албан тоот хүргүүлэн нээлгэж бүртгэлийн үйл ажиллагааг тухайн сумдад хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлж ажиллалаа. Иргэний улсын бүртгэлийн анхан шатны нотлох баримтыг хэрхэн цахимжуулах, баримтыг цахимжуулахад анхаарах асуудал сэдвээр 2 удаа, мөн тоон гарын үсгийн тухай сургалтыг 2 удаа тус тус 4 удаа онлайнаар зохион байгуулсан сургалтад улсын бүртгэгчид бүрэн хамрагдсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газраас зохион байгуулсан жендерийн эрх тэгш байдлыг хангах хуулийн тухай, мэдэгтүн сахигтун, хүмүүн байхын учир зэрэг 3 удаагийн онлайн сургалт Иргэний улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан аймаг нийслэл сум дүүргийн ИТХурлын нөхөн сонгуулийн тухай, иргэний улсын бүртгэлийн анхан шатны нотлох баримтыг цахимжуулах тухай, тоон гарын үсгийн тухай, гадаад паспортын зураг засвар, олголтын программ, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн тухай, Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан улсын бүртгэлийн байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа, хэрэг маргааны явцад хяналт тавих журам ” зэрэг 7 удаагийн сургалт нийт 10 удаагийн сургалтад холбогдох албан хаагчид хамрагдлаа. Хэлтсийн сургалтын төлөвлөгөөний дагуу Авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалт, Хувь хүний хөгжил, терроризм, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тайлагналт, хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай зэрэг 5 удаагийн сургалтад хамрагдлаа.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Аз жаргалтай ажиллахын нууц, төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлагын өөрчлөлт бүтээмжийг дэмжих, цахим хөгжлийн багц хууль, Төрийн албан хаагчийн гүйцэтгэл үр дүн төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих, “Стресс менежмент”, “Монгол улсын үндэсний болон гадаад аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудлууд” , 20 дугаар зууны монгол улсын гадаад харилцааны тойм, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан” Авлига гэмт хэрэг ” зэрэг 20 удаагийн онлайн сургалтад тус тус хамрагдсан байна.

Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа иргэдэд ил тод нээлттэй, хүртээмжтэй хүргэх,



хууль тогтоомжоо сурталчлах ажил иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хувьд гол ажлын нэг бөгөөд засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилго нь иргэдэд эрх зүйн мэдлэг мэдээллийг цахим болон цахим бусаар хүртээмжтэй энгийн, хялбар ойлгомжтой аргаар хүргэхэд оршино гэж заасан байдаг. Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн тасгаас 90 удаагийн сургалт мэдээллээр 5540 иргэнд бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилж ажилласан байна.

- ❖ Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд *Бүртгэгч багш* мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж ирсэн бөгөөд эхний хагас жилд Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулийн 12а, 12б ангийн 60 сурагч, Дэрэн, Өлзийт, Гурвансайхан сумдын ерөнхий боловсролын сургуулийн 8-9 дүгээр ангийн 210 сурагч нийт 270 хүүхдүүдэд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжоор мэдээлэл хүргэлээ. Сурагчдын дунд *Алтан хонх* танин мэдэхүйн уралдааныг зохион байгуулж идэвхтэй оролцсон түрүүлсэн сурагчдыг дурсгалын зүйлээр урамшууллаа. Танин мэдэхүйн тэмцээн уралдаанд идэвхтэй оролцсон 12 сурагчдыг урамшуулахад аймагт үйл ажиллагаа явуулдаг *Дээгий*салон, *Call center*, *Амина* салон зэрэг хувийн хэвشلүүд ивээн тэтгэн хамтран ажиллалаа.



- ❖ 2022 оны 5 сарын 2-ны өдрөөс Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол улсын 16 насанд хүрсэн иргэдэд тоон гарын үсэг олгох ажил эхэлсэн. Тус ажлын хүрээнд Гурвансайхан, Өлзийт,

Дэрэн сумдын Засаг даргын тамгын газартай хамтран тус сумдад зохион байгуулагдсан *Малчдын өдөрлөгт* оролцон тоон гарын үсгийн тухай ойлголт, тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдол, E-mongolia цахим системийн талаар 980 гаруй малчдад мэдээлэл өгч, 75 иргэний гар утсанд e-mongolia апплейкешн суулган заавар зөвлөгөө өгч, 178 иргэнд тоон гарын үсэг олголоо. Мөн Засаг даргын шуурхай хуралдаан болон банк санхүүгийн байгууллагын албан хаагчид, Сайнцагаан сумын ахмадын цуглаанд нийт 150 албан хаагчдад мэдээлэл хүргэлээ.



- ❖ Тус хэлтэс тоон гарын үсгийг эрчимжүүлэх тухай УБЕГазраас ирсэн чиглэлийн дагуу Луус сумын зөөврийн тоног төхөөрөмжийг 10 сард 2 удаа, 11 сард 3 удаа

ирүүлэн ерөнхий боловсролын Эрдмийн далай цогцолбор сургууль, Цэгц билэг сургууль, Политехникийн коллеж, Хүмүүнлэг сургууль, Мандал сургуулийн сурагчид, багш албан хаагчдад тоон гарын үсгийн талаарх мэдээллийг хүргэж 350 иргэнд тоон гарын үсэг олголоо. Мөн Мандал худалдааны төвөөр үйлчлүүлж байгаа 130 иргэнд тоон гарын үсэг олголоо.

- ❖ Канад улсын Засгийн газрын санхүүжилттэй Мерит төсөл, Эрдэнэссилвер ресурс ХХК –тай хамтран Гурвансайхан суманд зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон 150 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.



- ❖ Иргэд олон нийтэд иргэний гэр бүлийн бүртгэлийн сар бүрийн статистик тоон мэдээгээр инфографик мэдээг бэлтгэн хэлтсийн олон нийтийн фэйсбүүк хуудас болон

dundgovi@burtgel.gov.mn сайтад байршуулж хэвшсэн. Нийт 11 удаагийн инфографик мэдээлэл бэлтгэж хүргэсэн.

- ❖ 2022 оны 11 сарын 11-12 ны өдрүүдэд Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, иргэдэд мэдээ мэдээллийг хүртээмжтэй хүргэж, олон нийтийн санал хүсэлтийг сонсон шийдвэрлэх, цаашдын бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх зорилгоор Сайнцагаан сумын 9 багийн иргэдтэй хийсэн уулзалт мэдээллийн өдөрлөгт оролцон иргэдэд тоон гарын үсгийн талаарх мэдээллийг хүргэж ажиллалаа.
- ❖ Шинээр гэр бүл болж байгаа залуу залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүлийн үүрэг хариуцлага, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлээ батлуулахын утга учрыг ойлгуулах зорилгоор гэр бүлийг ёс төртэй баталж, гэрлэлтийн гэрчилгээ гардуулах ёслолыг зохион байгуулж ирсэн. Гэр бүлээ ёс төртэй батлуулж гэрлэлтийн гэрчилгээг авах хүсэлтээ ирүүлсэн Сайнцагаан сумын 6 хосын гэрлэлтийг баталж гэрчилгээг гардууллаа. Мөн олон улсын гэр бүлийн



өдрийг тохиолдуулан Гурвансайхан, Өлзийт, Хулд, Дэрэн сумдад шинээр



гэр бүл болсон 12 хосын гэрлэлт батлах ёслолын ажиллагааг зохион байгуулсан байна. Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор 20 дэх жилдээ уламжлал болон зохион байгуулагдсан "ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА"-г энэ

жил Монгол бахархалын өдөрт зориулан Аймгийн ИТХурал, ГБХЗХГазартай хамтран зохион байгууллаа байгууллаа. Уг ажиллагаанд ерөнхий боловсролын 5 сургуулийн 16 насанд хүрсэн нийт 40 сурагч иргэний үнэмлэхээ гардан авлаа. Ёслолын ажиллагаанд аймгийн ИТХурлын дарга С. Одэрдэнэ, аймгийн орлогч дарга М. Анхбаяр нар оролцож иргэний үнэмлэхээ гардан авсан сурагчдад иргэний үнэмлэхийг гардууллаа. ГБХЗХөгжлийн газраас хүүхдүүдэд гарын бэлэг өглөө.

- ❖ Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, цаг үеийн мэдээ мэдээллийг УБЕГазрын burtgel.gov.mn сайтаас Дундговь аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс, бүртгэлийн хэлтэс фэйс хуудас, du.burtgel.gov.mn вэйб хуудсанд шэйр хийж иргэд олон нийтэд мэдээлж ажиллалаа. Бүртгэлийн үйлчилгээний сургалт сурталчилгааг нийт 5544 иргэнд мэдээ мэдээлэл хүргэж ажилласан.



ХОЁР. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР


МУ-ын ХЗДХийн сайдын зөвшөөрлийн загвар батлах, нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинэчлэн олгох тухай тушаалыг тасгийн бүртгэгчиддээ танилцуулан мөрдөж ажиллаж байна.

2021 оны 04 сарын 08-ний өдрийн А/244 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс ирүүлсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт үзлэг хийх ажлын удирдамжийн дагуу Эрдэнэдалай сумын үл хөдлөхийн 200 хувийн хэрэгт тооллого хийж, нийт үйлчилгээний 432, нотлох баримтын хуудасны тоо 5808, шаардлагатай нотлох баримтын хуудасны тоо 4414, шаардлагагүй нотлох баримтын хуудасны тоо 1085 тоологдсон байна.

Үнэт цаас санхүүжилтийн корпорациас 2021 оны 11 сарын 04-ний өдрийн 97/21 тоот хүсэлтийн дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг төрийн банкны 2 хаан банкны 15 хоёр удаагийн 17 эд хөрөнгөд тусгай тэмдэглэл хийж бүртгэв.

Монголын ипотекийн корпораци ОССК-ын 2022.03.09-ны өдрийн 21/46-34 дугаартай албан тоотуудын дагуу хувийн хэргүүдэд хавсаргаж тусгай тэмдэглэл хийсэн.

Мөн монголын ипотекийн корпорацийн холбогдох мэргэжилтнүүдтэй нягт уялдаатай ажиллаж барьцааны гэрээ дуусгавар болгох тоот удаашралтай ирж байсныг өөрийн мэйл хаягаар авч бүртгэлийг хийн иргэдийн чирэгдлийг багасгаж ажиллаж байна. Мик актив хорин гурав ТЗК ХХК-ийн 2022 оны 03 сарын 29-ны өдрийн №21/06-20 тоотын дагуу 11 хувийн хэрэг болон нийт 2 удаагийн **22** хувийн хэрэгт тусгай тэмдэглэл хийж албан тоотыг хүргүүллээ.



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд улсын ахлах бүртгэгчид засвар өөрчлөлтийг хийх эрх олгосон. Засвар өөрчлөлтийг хийх талаар 2022 оны 04 сарын 07 -нд УБЕГ -ын даргын 7/2971 тоот чиглэлээр засвар өөрчлөлтийг үнэн зөв, бүрэн гүйцэд тусгаж оруулсан эсэхэд нэгж дэх хяналтын улсын байцаагч байнгын хяналт тавих, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулсан засвар өөрчлөлтийн тайланг 7 хоног бүр хяналтын байцаагчид өгч хяналт хийлгэж байх талаар чиглэл ирсэн. Тус чиглэлийг мөрдлөг болгон ажилласан. 2022 оны 04 сарын 10 -наас нийт 79 бүртгэлд засвар өөрчлөлт хийсэн байна. Эдгээр засвар өөрчлөлт нь цахимжуулалтын явцад Буян нэмэхийн өргөн чөлөө гэсэн гудамж сонгоогүйгээс гарсан алдаа зөрчил 50 хувийг эзэлж байна. Мөн программын шинэчлэл хийгдэх үед хийгдсэн бүртгэлийн дугаарлалтын алдааг засварлахад 20 хувьтай байна.

Хяналтын улсын байцаагчийн 2022 оны 03 сарын 02 -ны өдрийн 1500 дугаар дүгнэлтэд дурьдсан алдаатай нөхцөл байдал тогтоогдвол хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулахгүй засвар өөрчлөлт хийх гэсэн чиглэлийг баримтлан засвар өөрчлөлтийг хийж байна. Бусад ямар ч нөхцөлд хяналтын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн засвар өөрчлөлтийг хийж байна.

Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн “ERP” системийг үйл ажиллагаанд хэрэглэж хэвшиж байна. Өглөө бүр нэвтэрч аймаг орон нутаг болон төрийн албаны үйл ажиллагаанд өрнөж буй үйл явдал, бичиг баримт сослилцох бүх үйл ажиллагааг өөрийн ажиллагаанд хэрэглэж хэвшсэн. ЭХЭУБ-ийн үйл ажиллагааг үнэн зөв, түргэн шуурхай, орчин үетэй хөл нийлүүлэн ажиллах зорилгоор тасгийн хурлыг нийт 10 удаа хийж тухай бүр чиглэл өгч ажилласан байна. УБЕГ -ын даргын 2022 оны 05 сарын 30-ны өдрийн 6/4730 тоот чиглэлийн дагуу барьцааны гэрээ, барьцаалбар бүртгэх ЭУБ -06, ЭУБ-13 маягтууд ашиглан бүртгэл хийх талаар тасгийн хурлаар чиглэл өгч банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад хэлтсийн албан тоотоор чиглэл хүргүүлж ажиллах талаар ярилцаж барьцааны гэрээний хувийг авах, хадгалах шаардлагагүй талаар чиглэл өгсөн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг нийт **2811** мэдүүлэг хүлээн авч бүртгэл хийснээс **915** анхны бүртгэл, эрх шилжүүлэх **483** бүртгэл, бүртгэлд

өөрчлөлт **94**, барьцааны гэрээ **1254**, барьцааны гэрээ дуусгавар болох **596**, лавлагаа **62**-ийг бүртгэж, үйлчилгээний хураамж **19 680 195** төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого **101 737 961**, тэмдэгтийн хураамж **2 013 552** төгрөг нийт улсын төсөвт **123 431 708** мянган төгрөгийн орлого орууллаа.

Тайлант хугацаанд **2811** бүртгэл хийж анхны бүртгэлийн хувийн хэргийн **5490** хуудас, өмчлөх эрх шилжих **483** бүртгэлийн **2898** хуудас, барьцааны гэрээний **1254** бүртгэлийн **9170** хуудас, бусад бүртгэлээр **671** хуудас нийт 18230 хуудас цахимжуулж хэлтсийн архивт шилжүүлсэн байна.

Тус хугацаанд аймагт шинээр 20 айлын орон сууц 6, Гурвансайхан суманд 12 айлын орон сууц нэг баригдаж ашиглалтанд орсоноос гэрчилгээ олголт 90 хувьтай байна.

Эд хөрөнгийн бүртгэлийн тайлант хугацаанд **676** газар, **118** орон сууц, **65** хувийн сууц, **18** авто зогсоол, **8** үйлчилгээ, **4** агуулах, уурын зуух **2**, ажлын байр **1** бүртгэгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь тасгийн хурлыг **10** удаа хуралдуулж, ЭХЭУБГ-аас ирүүлсэн чиглэлийг хэлэлцэх, улсын бүртгэгчдийн ажил үүрэгт чиглэл өгөх, бүртгэлд хяналт хийж зөвлөн туслах болон дотоод асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэж ирсэн.

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн цахим системд бүртгэлийн төрөл, эд хөрөнгийн төрөл буруу сонгож бүртгэл хийгдсэн болон бусад засвар өөрчлөлт хийгдэх мөн улсын бүртгэлийн гэрчилгээ үрэгдүүлсэн бүртгэлүүдэд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан ахлах бүртгэгч засвар өөрчлөлтийн программ дээр засвар өөрчлөлт хийж ажиллаж байгаа нь бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, иргэдийг чирэгдүүлэхгүй ажиллахад ихээхэн ахиц гарсан.

Эд хөрөнгийн бүртгэлийн тоон мэдээг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Архивын мэдээг сар бүр гаргаж ажилласан. Газрын **11519**, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн **4280** хувийн хэрэг нийт **18577** хувийн хэрэг архивт нээгдэн хадгалагдаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А/244 дүгээр тушаалын 2 дахь хэсэгт заасны дагуу “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт үзлэг хийх” ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 5 дугаар сарын 01 -ний өдөр Эрдэнэдалай сумын ү-0813000001-0813000200 хүртэлх нийт 200 хувийн хэргийн 5808 ш нотлох баримтын хуудас бүхий үл хөдлөх эд хөрөнгийн хувийн хэрэгт үзлэг хийж 4414 ширхэг хуудас нь нотолгооны шаардлага хангасан, 1085 ширхэг хуудас нь нотлох баримтын ач холбогдолгүй болохыг тоолж, илэрсэн зөрчилийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр засвар өөрчлөлт хийсэн байна.

УБЕГ -ын 2022 оны 4 дүгээр сарын 29-ий өдрийн 6/376 тоот чиглэлийн хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын хувийн хэрэг, нотлох баримтуудын тооллого зохион байгуулж, цахим сантай тулгах, хувийн хэрэгт нь тусгаарласан баримтуудыг салган авч тусад нь хадгаламжийн нэгж үүсгэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд тус хэлтсийн даргын удирдамжийн дагуу 2022 оны 5 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 15- ны өдрийг хүртэлх

хугацаанд хийж, тусгаараласан баримтуудыг хяналтын байцаагч, эд хөрөнгийн бүртгэгчдийн хамт дахин хянаж хэлтсийн баримт бичиг нягтлан шалгах комисст хүлээлгэн өгсөн.

УБЕГ -ын ЭХЭУБГ- ын 2022 оны 11 дүгээр сарын 08-ий өдрийн 6/9582 тоот хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь нотлох баримт бичгээс зөрүүтэй,хуулийн этгээдийг иргэн төлөвтэй,хүчинтэй өмчлөгчийг барьцаалагчаар бүртгэгдсэн гэх мэт барьцаалагчийн мэдээлэл алдаатай бүртгэлийн жагсаалт,нэгж талбарын дугаар ороогүй газар өмчлөх эрхийн бүртгэлийн эх нотлох баримт бичгийг үндэслэн нэгж талбарын дугаарыг жагсаалтаар хүргүүлсэн улсын бүртгэлийн дугаар тус бүрийн арын харгалзах мөрөнд бичиж ирүүлэх,мөн эд хөрөнгийн хэмжээ ороогүй газар болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн жагсаалтаар хүргүүлсэн улсын бүртгэлийн дугаар тус бүрийн арын мөрөнд хувийн хэрэгт авагдсан эх нотлох баримт бичигт тодорхойлсон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээрт заасан үнийг улсын бүртгэлийн дугаарын арын мөрөнд бичиж ирүүлэх үүрэг даалгаврын дагуу аймгийн хэмжээнд үнийн дүн бичигдээгүй 33 бүртгэл жагсаалтаар ирүүлснийг хуульд заасны дагуу үнийг бичиж, барьцаалагчийн мэдээлэл зөрүүтэй 10 бүртгэлийг засвар өөрчлөлтийн эрхээр хяналтын газраас ирүүлсэн 1500 дугаартай хяналтын байцаагчийн дүгнэлтээр засвар өөрчлөлт хийж эд хөрөнгийн газарт илтгэх хуудсаар илгээж ажилласан.

Сар бүрийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний мэдээг инфографикт оруулж өмнөх оны мөн үе,энэ оны мөн үетэй харьцуулж мэдээлэл бэлтгэн аймгийн сайтад байршуулсан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгаас нийт **141** хүлээн авч, **114** бичиг явуулснаас Цагдаагийн газарт **46** тоотоор **230** иргэний үл хөдлөх эд хөрөнгийн лавлагааг хамаарал бүхий иргэдийн лавлагаатай хамт гаргасан ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт **39**, иргэний эд хөрөнгийн дэлгэрэнгүй лавлагаа, Дундговь аймаг дахь ШШГГ **39** лавлагаа,эрх түдгэлзүүлэх **19**, эрх сэргээх **17** бүртгэл хийж хувийн хэрэгт нь хавсарган архивт шилжүүлсэн.

ГУРАВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, “Хуулийн этгээд, түүний салбар төлөөлөгчийн газрын бүртгэл хөтлөх журмын дагуу дараах бүртгэлийг бүртгэсэн. Үүнд:

- Дахин гэрчилгээ олгосон-13
Хуулийн этгээдийн мэдээлэлд ХК 1, ХХК 72,Нөхөрөлөл 2, Хоршоо 13, ХЗХ 5, Улсын төсөвт үйлдвэрийн газар 10, Төрийн бус байгууллага 5, Шашны байгууллага 2 нийт 183 хуулийн этгээдэд нэмэлт өөрчлөлт хийж
- Лавлагаа олгосон -15
- Салбар төлөөлөгчийн газар бүртгэсэн -11
- Хяналтын дугаар олгосон- шинээр ххк 88 , дахин олгосон 23 нийт 111 хяналтын дугаар

- Шашны байгууллага хугацаа сунгасан-2
- Шинээр хуулийн этгээд бүртгүүлсэн ХХК 59 ,Нөхөрлөл 2, Хоршоо 7, Төрийн байгууллага албан газар 1, төрийн бус байгууллага 10, сан 1, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 1, нийт 81 бүртгэл, нийт 264 бүртгэл хийж архивд 1334 хувийн хэрэг байршиж байна.
- Хуулийн этгээдийн оноосон нэрийг e-mongolia системээр баталгаажуулалт хийж 525 нэрийг хүлээн авч татгалзсан 345, зөвшөөрсөн 89, баталсан 91 оноосон нэрийн бүртгэлийг баталгаажуулсан.
- Тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих лавлагаа олгох журам"-д зааснаар Хяналтын дугаар олгосон шинээр ххк 88 , дахин олгосон 23 нийт 111 хяналтын дугаар татан буугдсан, хэлбэр өөрчилсөн, гэмтээсэн, нэр өөрчлөгдсөн шалтгаанаар тамга хураан авсан улсын төсөвт үйлдвэрийн газрын 16, ХХК 6, Салбар 1, ААТҮгазрын 1 нийт 24 тамга тэмдгийг хураан авсан байна
- Хуулийн этгээдийн бүртгэлээс орон нутгийн орлогод 7597000 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн.
- Хуулийн этгээдийн бүртгэлд ирсэн 27, явсан 22 бичиг үүнээс хууль хяналтын байгууллагад 26, Хуулийн этгээдэд 12, бусад холбогдох байгууллагын албан бичиг байна.

Хуулийн этгээдийн бүртгэлд холбогдсон бусад зохион байгуулсан ажил



1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 02 сарын 22-ны өдрийн №64 тоот тогтоолын дагуу "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах комиссын гишүүнээр

ажиллаж хуулийн этгээдэд холбогдох мэдээллээр хангаж ажиллалаа.

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2,3 дугаар зүйлд заасанаар төрийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газрын бүртгэлийг 2019 онд 130 байгууллагын хэлбэрийг өөрчлөн бүртгэсэн бол энэ удаагийн тооллогоор үлдсэн байгууллага болох Мал эмнэлэгийн газар, Татварын хэлтэс, Зоонозын өвчин судлалын төв, Хөдөө аж ахуйн газар, Сум дундын ойн анги зэрэг үлдсэн газрыг бүртгэж дууслаа. Мөн энэ ажлын хүрээнд удирдлага нь өөрчлөгдсөн, хаяг өөрчлөгдөн бүртгэлийг тухай бүр шалгаж УТҮГ 52, байгууллагын бүртгэлийг цэгцэлсэн.



3. УБЕГ-аас ирүүлсэн 2022 оны 04 сарын 26-ны өдрийн №1/3681 тоот чиглэлийн дагуу УИХ-аас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн баталсан Татварын ерөнхий хууль/ шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулсан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэх ажлын хүрээнд нийт 318 хуулийн этгээдийн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн мэдээлэл ирснээс 54 хуулийн этгээд нөхөн бүртгэлд хамруулсан. үүнээс холбогдож чадаагүй 92, холбогдсон 66, хувьцаа эзэмшигч нас барсан 9, татан буугдсан 9, Хувьцаа эзэмшигч өөр газар байгаа 44, цаашдаа үйл ажиллагаа явуулахгүй 41, хориг тавьсан 3 зэрэг шалтгаануудтай байна.
4. УБЕГ, Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын 2022 оны 04 сарын 01-ны өдрийн 5/8779 албан бичгийн дагуу Улсын Их Хурал 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Хоршооны тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан хоршооны бүртгэлийг шинэчлэн бүртгэх ажлыг зохион байгууллаа. Дундговь аймгийн хэмжээнд нийт 98 хуулийн этгээд бүртгэлтэй байдаг боловч идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 20 гаруй хоршооноос Гурвансайхан сумын “Давших Зам”, Өлзийт сумын “Баян булаг”, “Рашаантын хөгжил” Говьугтаал сумын Угтаалын хишиг , Дэлгэрцогт сумын “Ширээс” Адаацаг сумын “Амьдралын туг”, зэрэг 150-аас дээш гишүүнтэй хоршоод шинэчилсэн бүртгэлдээ хамрагдаад байна.
5. Аймгийн ИТХ-ын ирүүлсэн 2022 оны 06 сарын 02-ны өдрийн 02241 тоот албан бичгийн дагуу Дундговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа сүм, хийд, шашны байгууллагад хяналт хийх хамтарсан комисст орж ажиллалаа. Тус шалгалтаар Дундговь аймгийн “Дашгиппилэн” хийд хугацаа сунгаагүй зөрчилтэй, “Баптист”, “Говийн гэрэл” сүмд хугацаа сунгасан, “Хос багана” чуулган нь улсын бүртгэлд бүртгэлгүй, дээд газар гэгдэх төрийн бус байгууллага нь шинэчилсэн бүртгэлд бүртгэгдээгүй тул заавар зөвлөгөөг өглөө.

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ИРГЭД ОЛОН НИЙТЭД
МЭДЭЭЛЛЭХ, СУРТАЛЧЛАХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ**

1. Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн А.Адьяасүрэнтэй хамтран Соёмбо танхимд “Хуулийн этгээдийг татан буулгах” талаар 15 сумын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн нийт 45 албан хаагчдад онлайнаар мэдээлэл хүргэж холбогдох асуултад хариулт өглөө.



2. 2022 оны 05 сарын 05-ны өдөр Дундговь аймгийн хоршоологчдын холбоо, Аймгийн ЗДТГ хамтран зохион байгуулсан хоршоологчдын нэгдсэн зөвлөгөөнд оролцож “Хоршооны тухай хуульд орсон өөрчлөлтүүд, дүрмийн шинэчилсэн бүртгэлд хэрхэн бүртгэх тухай сэдвээр 23 хоршооны 42 хоршооны дарга, гишүүдэд мэдээлэл өглөө.



Сургуулийн сурагч хүүхдүүдэд бүртгэлийн үйлчилгээг танилцуулах “Алтан хонх” сургалтын өдөрлөгийн талаар

1. Дундговь аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн даргаар батлуулсан төлөвлөгөөний



дагуу 2021 оны 11 сарын 04 ны өдрөөс эхлэн ахлах ангийн хүүхдүүдэд бүртгэлийн үйлчилгээний талаар мэдлэг олгох зорилготой “БҮРТГЭГЧ-БАГШ” үйл ажиллагааг санаачлан

эхэлснээ үргэлжлүүлэн 2022 оны 03 сарын 28-ны өдөр "Хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах" ажлын хүрээнд "Бүртгэгч-багш" өдөрлөгийг аймгийн “Цэгц-Билиг” сургуулийн 12а, 12б ангийн 60 сурагчдад:-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Иргэний бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өгч, "Алтан хонх" танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулан 12а ангийн сурагч н.Тэмүүлэн, н.Жамсран 12б ангийн сурагч н.Отгонхүү, Н.Ууганбаяр нар амжилттай оролцсон тул дурсамж хадгалуулав.

Мөн энэхүү арга хэмжээг ивээн тэтгэж оролцсон:

-Дээгий салоны захирал Д.Дэлгэрцэцэг 50 төгрөгийн үс засуулах эрхийн бичиг,

-Call center төвийн захирал Б.Мөнхтуяа 30 мянган төгрөгийн бүтээгдэхүүн авах эхийн бичиг,

-Амина салоны захирал М.Солонго 20 мянган төгрөгийн үйлчилгээ авах эрхийн бичгээр тус шагнаж хэлтсийн зүгээс гарын бэлэг дурсамж хадгалуулав.



2. 2022 оны 05 сарын 05-ны өдөр зохион байгуулсан Дэрэн сумын малчдын өдөрлөгт оролцож сумын ерөнхий боловсролын ахлах ангийн 11,10 дугаар ангийн 50 сурагч

нарт Хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн, Иргэний бүртгэлийн ахлах бүртгэгч Б.Сайхантуяа, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулийн этгээдийн Б.Одонтунгалаг нар хамтран Эд хөрөнгийн эрхийн бүртгэл, Иргэний бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэлээр сургалт явуулж “Алтан хонх” тэмцээн зохион байгуулан 1,2,3 дугаар байранд орсон сурагчид талархал хэлтсийн гарын бэлгийг гардуулав.



3. 2022 оны 05 сарын 16-нд Өлзийт сумын малчдын зөвлөгөөнд сумын сургуулийн 8, 9 дүгээр ангийн 30 сурагч нарт Эд хөрөнгийн эрхийн бүртгэл, иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлээр “Бүртгэгч багш” сургалт зохион байгуулан “Алтан хонх” тэмцээнд түрүүлсэн сурагч нар хэлтсийн талархал, гарын бэлгийг гардуулав.

4. 2022 оны 05 сарын 18-ны өдөр Гурвансайхан сумын “Малчдын зөвлөгөөнд сургуулийн ахлах ангийн 12,11 дүгээр ангийн 40 сурагч нарт “Бүртгэгч багш “ сургалтаа орж “ Алтан хонх” тэмцээн тэмцээнд түрүүлсэн хүүхдүүдэд талархал, хэлтсийн гарын бэлэг гардуулав. Сургалтаар холбогдох хариулт мэдээлэлд газар гэж юу вэ? эд хөрөнгө гэж юу вэ?, иргэний үнэмлэх гэж ямар бичиг баримт вэ? Компани гэж юу вэ? гэх мэтчилэн хүүхдүүдэд бүртгэлийн үйлчилгээг амьдралтай нь ойртуулж, хүүхдэд ойлгомжтой сургалт явуулж, 40 минутын хичээлийн цагийг маш үр дүнтэй өнгөрүүллээ. Ангийн хүүхдүүдийг баг болгон хувааж эд хөрөнгө, компани, иргэний бүртгэл гэх мэт асуулт тавьж баг тус бүр ярилцаж, өөрийн үзэл бодлоор хариулт өгч байлаа.



сургалтаар нийт 180 хүүхэд оролцож, 10 хүүхдийн талархал, гарын бэлэгт хэлтсийн зүгээс 200 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

ДӨРӨВ: БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

тайлант хугацаанд хялбаршуулсан журмаар 157 зөрчил шалган шийдвэрлэсэн. Үүнээс Зөрчлийн тухай хуулийн 15.24.4 дэх заалт иргэний үнэмлэх хаяж, үрэгдүүлсэн 40 иргэн, Зөрчлийн тухай хуулийн 15.24.1 дэх заалт иргэний үнэмлэх тогтоосон хугацаанд аваагүй 117 иргэнд зөрчил хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн. 2021 оны хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн 223 материалыг прокурорын газарт хүргүүлж хянууллаа.

Иргэн, ЭХЭУБ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2022 онд бүртгэлтэй холбоотой өргөдөл гомдлын нийт 53 дүгнэлт бичиж бүртгэлийн алдаа зөрчлийг арилгасан байна. Үүнд иргэний бүртгэлийн 42, хуулийн этгээдийн 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 8 дүгнэлт тус тус гаргасан байна.

2022 оны 11 дүгээр сард шинээр ашиглалтад орж буй хяналт шалгалтын программд тус онд гаргасан 53 дүгнэлтийг 100% цахимжуулж дуусгасан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн үйл ажиллагааг хянах удирдамж боловсруулж хяналтын ажил явагдаж байна. Хяналтын зорилго: Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын хэрэгжилтийг хангах, Улсын бүртгэгчийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд хэлтсийн дарга Ж.Өлзийжаргал, Хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн нар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч Ш.Нарангэрэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Н.Уугантуяа нарын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавилаа. Хяналт шалгалтын чиглэл нь

- Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн ашиглалт, хамгаалалт:

-Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 5.1.3-т заасан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл:

- Иргэн, Хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хүсэлтийн дагуу хийгдэх хяналт шалгалтын үйл ажиллагаа:

- Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тэмдэг хэрэглэх журмын хэрэгжилт:

-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох журмын хэрэгжилт:

-Үнэт цаасны зарцуулалт, тайлагналт:

-Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн хэрэгжилт:

- EPRS-2 хөтлөх журмын хэрэгжилт:

- Улсын бүртгэгч нарын ёс зүй, харилцаа, хандлагын талаарх иргэдийн санал, гомдол:

Удирдамжийн дагуу нийт 86 хувийн хэрэгт хяналт шалгалт хийснээс 23 алдаа зөрчил илэрч Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ш.Нарангэрэлд мэдэгдэл өгч алдаа зөрчлийг арилууллаа.

Мөн Дундговь аймгийн 15 сумын улсын бүртгэгч, хэлтсийн 11 албан хаагчдын 7416 бүртгэл, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажиллалаа. Төлөвлөгөөт 1, төлөвлөгөөт бус 9 шалгалт хийснээс бүртгэлийн төрлөөр ангилбал Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2811, иргэний бүртгэлийн 4535, хуулийн этгээдийн 32, архивын чиглэлээр 38 бүртгэлд хяналт шалгалт хийлээ. Үйлчилгээний төрөл нь

-Төрсний бүртгэл 701

-Гэрлэсний бүртгэл-151

-Үрчилсний бүртгэл-12

-Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-34

-Эцэг /эх/ тогтоосны бүртгэл-24

-овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-39

-Нас барсны бүртгэл-251

-Шилжилт хөдөлгөөний бүртгэл-1671

Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл-452



-Мэдээллийн сангаас олгосон лавлагаа-1210

-Газрын анхны бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл-915

-Эрх шилжих-483

-Бүртгэлд өөрчлөлт-94 тус тус байна. Нийт бүртгэлээс 153 алдаа зөрчил илэрсэн байна. Шалгалтын явцад илэрсэн алдаа дутагдлыг улсын бүртгэгч нарт нэг бүрчлэн танилцуулж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч цаашид энэ төрлийн зөрчил гаргахгүй байх талаар анхаарч ажиллах чиглэл, зөвлөмжийг өглөө.

Тогтвортой амжиргаа-3 төслийн сахүүжилтээр Говь-Угтаал, Өлзийт, Гурвансайхан, Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумдад очиж бүртгэлийн хяналт хийлээ.



Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуультай холбоотой Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас ирүүлсэн 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 7/3496 дугаартай чиглэлд тусгагдсаны дагуу 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртлэх хугацаанд бүртгэгдсэн 3 сумын 23 шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалт хийж хаягийг мэдээллийн сантай тулгалаа.

Дээрх чиглэлийн дагуу хавсралтаар ирүүлсэн Дундговь аймгийн Дэлгэрцогт сум, Сайхан-Овоо сум, Гурвансайхан сумын нотлох баримтад хийсэн хяналтаар, нотлох баримтын бүрдүүлбэр дутуу 2 зөрчлийг тухай бүр залрууллаа.

Хяналтаар Сайхан-Овоо сумын улсын бүртгэгч Ж.Энхжаргал нь иргэний үнэмлэхийн хуулбар аваагүй 2 шилжилт бүртгэсэн байсан бөгөөд тухайн иргэдээс нөхөж материалыг авч анхан шатны баримтад хавсаргав.

“Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын 10.3 дахь хэсэгт зааснаар бүртгэлийн дэвтэрт хянасан тэмдэглэлийг хийсэн.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн Б/701 тоот тушаалаар Дэлгэрхангай сумын улсын бүртгэгч Ц.Гэрэлтуяад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосон. Улсын бүртгэгчийн эрх олгогдсоноос хойшхи нийт 39 бүртгэлд хяналт шалгалт хийснээс дугаарлалтын алдаатай, нотлох баримт дутуу гэх 6 бүртгэлд зөвлөгөө мэдээлэл өгч, зөрчлийг арилгах арга хэмжээг авч цаашид энэ төрлийн зөрчил гаргахгүй байх талаар анхаарч ажиллах, хууль тогтоомж холбогдох чиглэл зөвлөмж өгч ажиллалаа.



Хяналт шалгалтын статистик мэдээг сар бүрийн 25-нд хяналтын газарт, зөрчил шалган шийдвэрлэсэн мэдээг сар бүрийн ажлын сүүлийн өдөр аймгийн Прокурорын газарт, үнэт цаасны тоог мэдээг сар бүрийн 1-ний өдөр няравт тус тус хүргүүлж ажиллалаа.

Сургалтын чиглэлээр: Хэлтсийн сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Төрийн албаны зөвлөлөөс нийт 29 сургалт, УБЕГ-аас зохион байгуулсан 18, аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан 3 сургалтад хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.

1. УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Нийслэл, орон нутаг дахь хэлтэс, тасгийн хяналтын улсын байцаагч нарт "улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар, өөрчлөлт оруулах тухай хяналтын улсын байцаагчийн дүгнэлт" сэдэвт цахим сургалт зохион байгууллаа.

2. Сургалтаар УБЕГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/424 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд түдгэлзүүлэх, цуцлах болон түздгэлзүүлсэн, цуцалсныг хүчингүй болгох тухай шийдвэрийн бүртгэл хөтлөх заавар”-ын танилцуулга, Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 806 дугаар дүгнэлт, Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1497, 1499, 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1543 дугаар дүгнэлт, Хяналтын улсын байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны 1500 дугаар дүгнэлтийн талаар тус тус сургалт зохион байгууллаа.

3. 2022 оны 03 сарын 29-нд улсын бүртгэгч нарт зөвлөмж чиглэл өгөх сургалт зохион байгууллаа.

4. УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр “Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны явцад хяналт тавих журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар цахим сургалт зохион байгууллаа. Сургалтад Хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч, эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч нар хамрагдлаа.

5. 2022.10.18-нд “Хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн сан, програмын танилцуулга сургалт

УБЕГ-ын даргын 2022.09.13-ны өдрийн Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь хэлтсээс иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалж үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийх шалгалтын удирдамжийн хүрээнд 21 аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага, иргэдээс үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэх, энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалсан үйлдэл байгаа эсэхийг шалгаж, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох, дахин энэ зөрчлийг гаргуулахгүй байхад чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, хүн хуулийн этгээдэд “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар хүлээсэн үүргийг танилцуулах зорилгоор 2022 оны 09 дүгээр сарын 23, 26-ны өдрүүдэд Дундговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй барьцаалан зээлдүүлэх газар, хүнсний дэлгүүр, ТҮЦ, Зочид буудал, бусад үйлчилгээний газруудад Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн цагдаа дэд ахлагч Б.Ренчиндоржтой хамтран аймгийн төвийн нийт 18 дэлгүүр, зочид буудал, гэр хорооллын дэлгүүр, барьцаалан зээлдүүлэх газруудаар хяналт шалгалт хийлээ. Үүнд: “Түмэн дэлбээ” ХХК, “Хөрх хайрхан” ХХК, “Нээ” ХХК, “Цанидноров” ХХК, “Хөрх булаг” ХХК, “Говийн манлай” ХХК, Хөөт булаг ХХК, Цоглог дэлгүүр, Чандмань баян хайрхан ХХК, гэх 9 барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, Ашид, Бүрд гэх 2 зочид буудал, 7 гэр хорооллын жижиг дэлгүүрүүдээр орж хяналт шалгалт хийхэд баримт бичиг барьцаалсан зөрчил илрээгүй.

-УБЕГ-ын даргын 2022.11.08-ны өдрийн эрсдэлд суурилсан улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамж, мөн өдрийн 7/9579 тоот чиглэлийн хүрээнд Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 01-ний хооронд хийсэн 400 бүртгэлийн үйлчилгээнд хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын үед илэрсэн нийт зөрчлөөс Төрөлтийн бүртгэлд СТ-4 маягт гарын үсэггүй, Гэрлэлтийн бүртгэлд гэрлэсний бүртгэлгүй лавлагаа 2 удаа цахимжиж орсон, цахим санд нотлох баримт оруулахдаа А-5, А-4-ийн сонголтыг сонгоогүй, хазгай оруулсан, нотлох баримт илүү оруулсан гэх мэт алдаа дутагдлыг улсын бүртгэгч нарт нэг бүрчлэн танилцуулж илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч цаашид энэ төрлийн зөрчил гаргахгүй байх талаар анхаарч ажиллах чиглэл, зөвлөмжийг өглөө.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 01 хооронд хийсэн 22 бүртгэлийн үйлчилгээнд хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын үед илэрсэн 1 зөрчил байсан бөгөөд хувийн хэргийн нотлох баримт дутуу цахимжуулсан алдаа гарсанаас зөрчлийг арилгах арга хэмжээг авч цаашид энэ төрлийн зөрчил гаргахгүй байх талаар анхаарч ажиллах, хууль тогтоомж холбогдох чиглэл зөвлөмж өгч ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 01 ний хооронд хийсэн 236 бүртгэлийн үйлчилгээнд хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын үед илэрсэн нийт 9 зөрчил гарсныг улсын бүртгэгч нарт танилцуулж, арилгаж болох зөрчлийг арилгуулж, анхаарах шаардлагатай асуудал, бүртгэлийг цаашид хууль тогтоомжийн дугуу хэрэгжүүлэх талаар сануулж ажиллалаа.

-2022.06.19-ны өдөр Гурвансайхан сумын 10-5-2-р хэсгийн нөхөн сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллалаа. Нийт 336 сонгогчоос 153 сонгогч санал өгч ирц бүртгэл 44.87%-тайгаар сонгуулийг амжилттай зохион байгууллаа.

-УБЕГазрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийн тусгаарласан баримтуудыг нэг бүрчлэн тоолж стандартын дагуу 250 хуудсаар нэгж үүсгэн 155 нэгжийн 38750 ширхэг тусгаарласан хуудсыг ББНШ Комиссоор хуралдаж хурлын тэмдэглэлийг УБЕГазарт хүргүүлсэн.

Хэлтсийн алба хаагчдын 1-11-р сарын үнэт цаасны тайланд хяналт хийж ажиллалаа.

ТАВ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН ТАЛААР

Тус хэлтэс нь УБЕГ-ын Даргын тушаалаар үндсэн 28, гэрээт албан хаагч 2, нийт 30 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Тус хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар 2022 оны 1 дугаар

сард аудит хийж санхүүгийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй, “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.

Тус хэлтэс 2022 оны 2-р улиралд нэмэлт санхүүжилтээр УБЕГ-ын Даргын 2022 оны 05-р сарын 11 өдрийн А/368 тоот тушаалаар батлагдсан 2022 оны Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардалд 5,766.6 мянган төгрөгийн санхүүжилт авч 5,766.6 мянган төгрөгийг сонгуулийн Итгэмжлэгдсэн ажилчдын цалин, албан томилолтын зардалд 100 хувь зарцуулсан.

Тайлант онд байгууллагын 5 ахмадад 2022 оны сар шинийн баяраар тус бүр 150,0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл, 5-р сард өндөр настан П.Тогосмаад өрхийн тарайлан эрхлэхэд нь зориулж 3,000.0 мянган төгрөгийн 1 удаагийн дэмжлэг, 3-р улиралд ахмадын баяраар тус бүр 101.2 мянган төгрөгийн бэлэг нийт 4,256.2 мянган төгрөгийг Ахмадын сангаас зарцуулсан.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2022 оны 2-р сард 2021 оны жилийн эцсийн өмчийн мэдээ, захиргааны статистик маягтыг нөхөж хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

МУЗГ-ын 2020 оны 1-р сарын 8-ны өдрийн №9 тогтоол, УБХ-ийн Даргын 2022 оны 5-р сарын 23-ны А/07 тоот тушаалаар 5-р сарын 23-28 өдрүүдэд үндсэн хөрөнгийн улсын тооллого хийгдэж, тооллогоор үндсэн хөрөнгийн илүүдэл, дутагдал илрээгүй. ТӨБЗГ-аас тус хэлтсийн 2021 оны Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ болон 2022 оны улсын тооллогын дүнд маш сайн буюу А /95/ үнэлгээ өгсөн. Хагас жилийн бараа материалын тооллогыг Хэлтсийн Даргын 2022 оны 6-р сарын 21-ны А/10 тоот тушаалаар тооллогын комисс тооллого хийж, тооллогоор илүүдэл, дутагдал илрээгүй.

УБЕГ-аас орон нутаг дахь хэлтсүүдэд “Эд хөрөнгө, иргэн, хуулийн этгээдийн хувийн хэрэг хадгалах нягтруулсан шүүгээ бэлтгэх арга хэмжээ” –тэй холбоотой шууд худалдан авалтын эрх шилжүүлсэнтэй холбоотой 62,400.0 мянган төгрөгийн санхүүжилт 11 сард нэмж орсон болно.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон үйлчилгээний орлогын 1-р сараас 11-р сарын мэдээг тус бүр 11 удаа УБЕГ-т хүргүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн 1-р сараас 11-р сарын тайланг сар бүр нийт 11 удаа, 2021 оны 4-р улирал, 2022 оны 1, 2, 3-р улирлын татварын тайланг цахимаар тоон гарын үсгээр

баталгаажуулан улирал бүр нийт 4 удаа гаргаж харъяа байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 01 өдөр хүртэлх хугацаанд нийт 133 мэдээлэлийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 133 мэдээллийг хугацаа хоцролгүй үнэн зөв, бүрэн байршуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2022 оны 2-р сарын 28 өдөр хуралдаж, анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй, хуучин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, автотээврийн хэрэгслийг актлах дүгнэлт гаргасан. 2022 оны 3-р улиралд УБЕГ-ын СААХ-т авто тээврийн хэрэгсэл 1, машин тоног төхөөрөмж 8, тавилга эд хогшил 4, нийт 3 нэр төрлийн 13 ширхэг 24,153.8 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө актлах санал хүргүүлсэн.

Тус хэлтэс нь 2021 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар НДШ-ийн 11,919.4 мянга, байр ашиглалттай холбоотой байрны түрээсийн зардлын 775.8 мянга нийт 12,695.2 мянган төгрөгийн өртэй ажиллаж байна. Уг өр төлбөр нь 2022 оны төсвийг батлахдаа төсвийн төсөлд тусгасан дүнгээс хасаж баталсан. Цалингийн зардлын төсвийг 2021 оны орон тоо дутуу үеийн цалингийн зардлын гүйцэтгэлээр баталсан нь тайлант онд бүтэн орон тоогоор ажиллаж зөрүү үүссэнтэй холбоотой байна. Дээрх өр төлбөрийг 2022 оны 12 сард бүрэн барагдуулахаар СААТ-т холбогдох судалгаа, гэрээ зэргийг хүргүүлэн ажиллаж байна.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААР

Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмж, сүлжээний эвдрэл гэмтлийн засвар үйлчилгээ, программын шинэчлэлт хийх зэрэг ажлуудыг тухай бүрт нь түргэн шуурхай хийж гүйцэтгэн, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа. Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмжийн нууцлал, аюулгүй байдлыг ханган нууц үг, нэвтрэх нэрийг солих зэрэг ажлуудыг тухай бүрт нь түргэн шуурхай хийж гүйцэтгэн, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа. Үүнд: Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмжийн нууцлал, аюулгүй байдлыг ханган нэвтрэх нэр, нууц үгийг I, II, III улиралд солин, тоног төхөөрөмжийн нууцлалыг хангаж ажиллалаа.

Хэлтсийн 29 албан хаагчдын мэдээлэл тээгч техник, хэрэгслийн үзүүлэлтийг гарган, хувийн хэргийг хөтлөн, хавтаслалаа.


Хэлтсийн вэб сайтад текстэн мэдээ 110, видео мэдээ 22 бэлтгэн хөгжүүлэлт хийлээ. Үйлчилгээний сар бүрийн нэгтгэсэн тоон мэдээгээр 1 сараас 11-р сарын инфографик мэдээлэл бэлтгэн сар бүрийн 28-ны дотор олон нийтэд хүргэн, вэб сайтад байршууллаа. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.19-д заасан арга хэмжээг заасан хугацаанд вэб сайт, фэйсбүүк пэйж хуудсанд нийт 150 мэдээг бэлтгэн, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор ханган ажиллалаа. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, hgm.csc.gov.mn цахим системээр нэвтрэн хэлтсийн албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулан ажиллалаа.

ДОЛОО. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

1. Аймгийн ЗДТГазарт ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар санал төсөл боловсруулан хүргүүлснээр тус хэлтсийн ажлын байранд урсгал засвар хийх 7,7 /долоон сая долоон зуун мянга/-н төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүллээ.



2. Говь-Угтаал сумын сүлжээний төхөөрөмж шинэчилэх зардалд 400,0 төгрөгийн дэмжлэг авч бүрэн шинэчилж ажиллагаанд орууллаа. Дэрэн, Өлзийт, Гурвансайхан, Цагаандэлгэр сумдын ЗДТГазартай хамтран ажиллаж шатахуун хоол унааны зардлыг /500,0 төг/ шийдвэрлүүлэн малчдын өдөрлөгт оролцсон Тоон гарын үсэг олгох болон бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчилан үйлчилгээ үзүүллээ.



3. Эрдэнэдалай сум, Дэрэн сумдад төлбөрийн Гэрэгэ системийг суурьлуулах хөрөнгийн асуудлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бүрэн шийдвэрлүүллээ. Орон

нутгаас эхний хагас жилийн байдлаар нийт 16,6 сая төгрөгийн дэмжлэг авсан байна.

4. 2022 онд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Тогтвортой амьжиргаа -3” төсөлтэй хамтран хөдөөгийн багийн иргэдэд бүртгэлийн үйлчилгээг сурталчилах зөвөлгөө мэдээлэл хүргэх зорилгоор хөдөөгийн 15 суманд 2 албан хаагч ажиллаж хамтран ажиллах гэрээний дагуу

- шатахуун, томилолтын зардал 3,8 сая төгрөгийн дэмжлэгийг авлаа. ГХБХБГазартай хамтран хаягжуулалтын санг цэгцлэх, сумдад кадастрын бүртгэлтэй хамт явж улсын бүртгэл хийж уг үйл ажиллагаанд 2 сумыг хамруулан ажиллалаа.
5. Аймгийн ГХЗХГазартай хамтран ажиллаж 12 хосын гэрлэлтийг ёслол төгөлдөр баталж санхүүжилт 1200,0 төгрөгийн бодит дэмжлэгийг авлаа.
 6. Хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Сайнцагаан сумын бүртгэгч Ш.Чулуун, Иргэний бүртгэлийн улсын бүртгэгч Ё.Батбаяр нар тус бүр 10,0 сая төгрөгийн орон сууцны буцалтгүй дэмжлэгийг авч нийт 20,0 /хорин сая/ төгрөгийн орон сууцны тэтгэлэгт албан хаагчдыг хамрууллаа.



ХОЁР.Идэвх, санаачилга, шинэлэг ажлын тайлан

1. 2022 онд Байгууллагын соёлыг бий болгох, Хандлагаа өөрчилье цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллалаа. Тайланг зургаар оруулав.



**ДУНДГОВЬ АЙМАГ
ДАХЬ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТЭС**

**“ХАНДЛАГАА ӨӨРЧИЛЬЕ-ХАМТДАА
ХӨГЖЬЕ”
АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**УРИА
“ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨНӨӨДРӨӨС”
ЗОРИЛГО
“ЗӨВ ДАДАЛ ЗӨВ АМЬДРАЛД ХӨТӨЛНӨ”**

БАТРАЙ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСИЙН
ДАГЛАГЧ **С.САНДУУГАА** Ж.ӨЛШИЙН АРГАЛ

“Хандлагаа өөрчилъе-Хамтдаа хөгжъе” аяны хуралдаан

№	Зохион байгуулах арга хэмжээний нэгж	Хийгдэх арга хэмжээ	Хариуцаж ажиллахаар байгаа ажилтан
1.	Аяны тийт албан хаагчид танилцуулж, төлөвлөгөө гарган баталж, баримтлуулах.	Аяны төлөвлөгөө өргөж албан хаагчид танилцуулж, Урьд зоригийг албан хаагчид хандуулах, хийгдэх ажилдаа хамрагдахыг тавих байгууллага.	Л.Мөнхсайрай Г.Намнан Н.Уугануула
2.	Сам, байгууллага бүр дэвтэй холбоотой урьд зоригтой болон баях, хандлагааг газар баруудад, амьдрал, бус мэдлэг байх.	Аяны хандлага зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, хөжөөр, тэрийн төлөвлөгөө, зорилготой зохион байгуулах үүдэлтэй танилцуулж.	Г.Далтан-Од М.Сонголтуула
3.	Сам, байгууллага бүр аяны зорилготой үндэсний өсө, дорнод, зорилготой албан хаагчид дүн зохион байгуулах.	Байгууллага тус албан хаагчид өс зүй, хөжөөр хандлагаг сайруулах, тэдний биедээ өргөжлөг чадварыг нэмэгдүүлж зорилготой урьд зоригийг тавих.	Ш.Нарангуйл Г.Далтан-Од
4.	Тэрийн албан хаагчид өс зүй, зорилготой хандлагаг хариуцаж урьд зоригийг тавих.	Аяны хандлагаг сайруулах, баримт бичгийн өс зорилготой хөжөөр, аяны байрны орчин төлөвлөгөөг сайруулах гэж мэт сэдвээр албан хаагчид дүн зуулалт хийгдүүлж 2-оос дорнод үйл ажиллагаа зохион байгуулах.	Ж.Өлзийн аргал Г.Намнан
5.	Аяны хандлагаг сайруулах, баримт бичгийн өс зорилготой хөжөөр, аяны байрны орчин төлөвлөгөөг сайруулах гэж мэт сэдвээр албан хаагчид дүн зуулалт хийгдүүлж 2-оос дорнод үйл ажиллагаа зохион байгуулах.	Аяны хандлагаг сайруулах, баримт бичгийн өс зорилготой хөжөөр, аяны байрны орчин төлөвлөгөөг сайруулах гэж мэт сэдвээр албан хаагчид дүн зуулалт хийгдүүлж 2-оос дорнод үйл ажиллагаа зохион байгуулах.	Н.Уугануула
6.	Аяны байрны орчин төлөвлөгөөг сайруулах, баримт бичгийн өс зорилготой хөжөөр, аяны байрны орчин төлөвлөгөөг сайруулах гэж мэт сэдвээр албан хаагчид дүн зуулалт хийгдүүлж 2-оос дорнод үйл ажиллагаа зохион байгуулах.	Тэрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд тэрийн албаны өс зүй зорилготой байрны орчин төлөвлөгөөг сайруулах, баримт бичгийн өс зорилготой хөжөөр, аяны байрны орчин төлөвлөгөөг сайруулах гэж мэт сэдвээр албан хаагчид дүн зуулалт хийгдүүлж 2-оос дорнод үйл ажиллагаа зохион байгуулах.	Бүх албан хаагчид
7.	Урьд зоригийг тавих, зорилготой хөжөөр, аяны байрны орчин төлөвлөгөөг сайруулах гэж мэт сэдвээр албан хаагчид дүн зуулалт хийгдүүлж 2-оос дорнод үйл ажиллагаа зохион байгуулах.	Урьд зоригийг тавих, зорилготой хөжөөр, аяны байрны орчин төлөвлөгөөг сайруулах гэж мэт сэдвээр албан хаагчид дүн зуулалт хийгдүүлж 2-оос дорнод үйл ажиллагаа зохион байгуулах.	

**УРИА
“ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨНӨӨДРӨӨС”
ЗОРИЛГО
“ЗӨВ ДАДАЛ ЗӨВ АМЬДРАЛД ХӨТӨЛНӨ”**

Зөв дадал зөв амьдралд хөтөлнө зорилгын хүрээнд “Өөрчлөлтийг өнөөдрөөс” уриа дэвшүүлж, албан хаагчдын хандлагыг өөрчлөх, эерэг сэтгэгдэл төрүүлэх үүднээс зурагт самбар хийж албан хаагчдыг бие биедээ талархлын захидал бичиж, сэтгэлийн илгээмж өгөх өдрийг зохион байгууллаа.

**УРИА
“ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨНӨӨДРӨӨС”
ЗОРИЛГО
“ЗӨВ ДАДАЛ ЗӨВ АМЬДРАЛД ХӨТӨЛНӨ”**



Гурвансайхан суманд зохион байгуулсан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх өдөрлөгөөр “Хандлагаа өөрчилъе- Хамтдаа хөгжъе” нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа.





1. "ӨӨРИЙГӨӨ ХАЙРЛАХУЙ БА СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДЭЭ ТОРДОХ НЬ" сургалт зохион байгуулагдлаа.

* ГБХЗХГазар, "Хөөрхөн зүрх" ТББ- тай хамтран эмэгтэйчүүдийг өөртөө цаг гарган өөрийгөө хайрлах арга барилд суралцуулах, өөрийгөө танин мэдэж байгаагаар нь хүлээн зөвшөөрөх, улмаар сэтгэл хөдлөлөө удирдан стресс, бухимдлаа зөв аргаар тайлах зорилгоор "Өөрийгөө хайрлахуй ба сэтгэцийн эрүүл мэндээ тордох нь" сургалтанд хэлтсийн эмэгтэйчүүд хамрагдлаа.

2. Боловсрол соёлын мэргэжилтэн Б.Цэцэгийг урьж “Аз жаргалтай ажилтан, Бүтээмжтэй ажилтан” сургалтанд хамрагдлаа.



3. Ахмадын баярын өдрөөр ахмадууддаа хүндэтгэл үзүүлж байгууллагын албан хаагчид “ХАНДЛАГАА ӨӨРЧИЛБЕ-ХАМТДАА ХӨГЖЬЕ” сэдвээр ярилцлага зохион байгууллаа.



- Нэг цэгийн үйлчилгээний заалны шал, бүртгэгч нарын сандлыг шинээр авч, хаягийг шинэчилж албан хаагчийн ажиллах таатай нөхцөлийг бүрдүүллээ



Иргэдийг сайн сайханд уриалсан залуу хосын гэрлэлтийн ёслолыг дурсгалтайгаар үлдээх зорилгоор аймгийн төв, сумын төв, малчны хотонд нийт 15 гэрлэлт баталлаа.



“МОНГОЛ БАХАРХАЛЫН ӨДӨР”-ыг угтаж “ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ”-ийн үйл ажиллагаа зохион байгууллаа. Тус арга хэмжээнд аймгийн төвийн 5 сургуулийн 40 хүүхэд ИРГЭНИЙ АНДГАЙ өргөлөө.

